



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ТОГТООЛ**

2015 оны 06 сарын 17 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Өргөдлийн байнгын хорооноос **ТОГТООХ** нь:

1. Гэр хорооллын нөхцөлийг сайжруулах ажлын хүрээнд дахин төлөвлөлтийн төслийн хэрэгжилттэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн өргөдөл, төсөл хэрэгжүүлэгч зарим аж ахуйн нэгжүүдийн хүсэлтийг хэлэлцээд дараах арга хэмжээг авч ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т чиглэл болгосугай:

1/Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох, ялангуяа газар чөлөөлөх болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээний асуудалд анхааран ажиллах;

2/Улсын Их Хурлын 2010 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Шинэ бүтээн байгуулалт” дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж байгаа “100 мянган айлын орон сууц” төслийг Гэр хорооллыг дахин төлөвлөх төсөлтэй уялдуулан хэрэгжүүлэх;

3/Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэх хүрээг өргөжүүлэх талаарх иргэдийн хүсэлт болон гэр хорооллыг орон сууцжуулах төсөл нь урт, дунд хугацаанд хэрэгжих зэргийг харгалзан инженерийн дэд бүтцийн барилга байгууламж, шугам сүлжээний ажлыг төсөл хэрэгжих хугацаатай уялдуулан төлөвлөж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулж ажиллах;

4/Дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлэхэд инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, инженерийн зураг төсөл, барилга угсралтын ажлыг санхүүжүүлэх, хөрөнгө оруулалт хийх төсөв батлагдсан ч санхүүжилт хийгдэхгүй байгаагаас барилгын ажил удааширч төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, иргэд хохирч байгаа тул эн тэргүүнд барилгын ажлаа эхлүүлсэн талбайд санхүүжилт, хөрөнгө оруулалт хийхэд анхаарч ажиллах;

5/Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төсөл хэрэгжүүлж байгаа талбайд тухайн компани газар чөлөөлөхөд зарцуулсан хөрөнгө, болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний зураг төсөл хийгдсэн байдал зэргийг харгалзан цэцэрлэг, сургууль болон бусад нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж барих ажлыг төсөл хэрэгжүүлэгч компанид концессын гэрээгээр гүйцэтгүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх;

6/Дахин төлөвлөлтийн ажилд ус, дулаан, цахилгаан хангамжийг, эх үүсвэрийг шийдвэрлэх шинэлэг арга хэлбэрүүдийг судлан, шаардлагатай

тохиолдолд мөрдөгдөж буй стандартыг шинэчлэн батлуулах;

7/Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ач холбогдлыг иргэдэд тайлбарлан таниулах, соён гэгээрүүлэх ажлыг тасралтгүй явуулж, эерэг хандлага төлөвшүүлж дахин төлөвлөлт хийхээр батлагдсан байршилд төсөлд оролцогч иргэдийн эрх, үүргийн талаарх мэдээллийг оршин суугчдад ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэж, тухайн дүүрэг, хорооны холбогдох албан тушаалтнуудад дахин төлөвлөлтийн асуудлаар сургалт зохион байгуулж, ажлын уялдааг хангахад анхаарах;

2.Тогтоолын биелэлтийг 2015 оны 12 дугаар сарын 25-ны дотор тус Байнгын хороонд танилцуулахыг Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т даалгасугай.

ӨРГӨДЛИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



О.БААСАНХҮҮ